



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 07 сарын 22 өдөр

Дугаар 64

Номгон

Монгол Улсын Төрийн дээд шагнал
“Алтан гадас” одонгоор “Баянхонгор-Эрчим хүч”
цахилгаан түгээх ХХК-ийг шагнуулахаар
өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дугаар заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, “Баянхонгор-Эрчим хүч” цахилгаан түгээх ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл, хамт олны санал, аймгийн Засаг даргаас ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Баянхонгор аймгийн төв, хөдөө орон нутгийн нийт ард иргэдийг найдвартай цахилгаан эрчим хүчээр хангах, түгээх, борлуулах үйл ажиллагааг 1966 оноос эхлэн тасралтгүй явуулж байгаа “Баянхонгор-Эрчим хүч” цахилгаан түгээх ХХК-ийн 50 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Төрийн дээд шагнал “Алтан гадас” одонгоор шагнуулахаар тодорхойлолтыг Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 07 сарын 22 өдөр

Дугаар 05

Номгон

Аймгийн Сонгуулийн хороо
байгуулах тухай

Монгол Улсын Сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.6, 16 дугаар зүйлийн 16.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үүрэг бүхий аймгийн Сонгуулийн хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Аймгийн Сонгуулийн хорооны дарга Д.Юндэнбазар-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга

Нарийн бичгийн дарга Т.Норов-Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга

Гишүүд Г.Батбаяр-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга

Г.Энхбаяр-Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын мэргэжилтэн

Ц.Байгальмаа-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны мэргэжилтэн

Н.Мэндбаяр-Хөдөлмөрийн хэлтсийн мэргэжилтэн

Б.Батбаяр-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хянапт, шинжилгээ үнэлгээний мэргэжилтэн

2.Сумдын сонгуулийн хороог хуулийн хугацаанд байгуулан, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Сонгуулийн хорооны дарга /Д.Юндэнбазар/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

115381